



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 52

Мөрөн

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөрөн сумын 8 дугаар багт Голын эргийн байрны баруун талд байрлах “Хөвсгөл Ус Суваг” ХХК-ийн эзэмшилд байгаа 3856 м.кв газраас “Хөвсгөл Ус Суваг” ХХК-д 1364 м.кв газар эзэмших эрхийг хэвээр үлдээж, 2057,4 м.кв газрыг “Хоймор нутгийн чулуу” ХХК-д, 434,6 м.кв газрыг Орон нутгийн өмчийн газарт, Мөрөн сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт “Олон гол” трейдийн баруун талд байрлах Хот тохижилт үйлчилгээний төвийн 2000 м.кв газар эзэмших эрхийг “Хоймор нутгийн чулуу” ХХК-д, Мөрөн сумын 7 дугаар багт “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн ард байрлах аймгийн Засаг даргын тамгын газрын 3080 м.кв газар эзэмших эрхийг Хөвсгөл аймгийн Авто тээврийн төвд шилжүүлэхийг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/-д зөвшөөрсүгэй.

2. Газар эзэмших эрхээ баталгаажуулахтай холбоотой материалыг бүрдүүлж, аймгийн Засаг даргад уламжлахыг байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 76 дугаар тогтоолын хавсралтаас “Хоймор нутгийн чулуу” ХХК-д 298413 дугаартай 3856 м.кв газрыг шилжүүлэх гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Гончиг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР